

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны
7 дугаар сарын 07-ны өдрийн Р-2023-37 дугаар тогтоолын Хавсралт



ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН
УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ДҮРЭМ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны
7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-37 дугаар тогтоолын Хавсралт

Хувилбар	2.0
Баталсан огноо	2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр
Баталсан	Төлөөлөн удирдах зөвлөл
Боловсруулсан	Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба
Холбогдох эрх зүйн баримт бичгүүд	▪ Компанийн тухай хууль ▪ Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын кодекс
Дагаж мөрдөх	Банкны хэмжээнд
Нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх, хүчингүй болгох	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батална.

АГУУЛГА

1. НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ХОРООНЫ ЗОРИЛГО
2. ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ХОРООНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮТЭЦ
3. ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ХОРООНЫ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Нэгдүгээр зүйл. Хорооны зорилго

- 1.1 ХасБанк (цаашид “Банк” гэх)-ны Төлөөлөн Удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо (цаашид “Хороо” гэх)-г Банкны ТУЗ-өөс өөрийн эрх, үүргийг хэрэгжүүлэх, Банкны гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн гишүүд болон хувьцаа эзэмшигчдийн түвшинд Компанийн засаглалын тогтолцооны хэрэгжилтийг хянах зорилгоор үүсгэн байгуулна. Энэхүү тогтолцоо нь Банкнийг хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, түүнчлэн, гүйцэтгэх удирдлага, ажилтнууд, өргөн хүрээний бусад оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн ил тод, тогтвортой удирдлагаар хангахад чиглэсэн бүтэц, үйл ажиллагаатай байна.
- 1.2 Хороо нь ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захирал (цаашид “ГЗ” гэх)-ын албан тушаалд мэргэжлийн өндөр ур чадвартай нэр дэвшигчийг сонгон шалгаруулах, үнэлэх болон зөвлөмж болгох замаар ТУЗ-ийн хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, Банкны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий зохицуулагч байгууллага, засгийн газрын агентлагийн өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.
- 1.3 Хороо нь дараах үүргийг нэн тэргүүнд хэрэгжүүлэх ба үүгээр хязгаарлагдахгүй:
 - (a) Банкны засаглалын кодекс, засаглалын тогтолцоог боловсронгуй болгох талаар ТУЗ-д зөвлөмж хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
 - (b) ТУЗ-ийн хараат бус болон ердийн гишүүн, ГЗ-ын албан тушаалд сонгогдох, эсхүл томилогдох мэргэжлийн ур чадвартай нэр дэвшигчийг сонгох, үнэлэх, ТУЗ болон Банкны хувьцаа эзэмшигчдийн хуралд зөвлөмж болгох;
 - (c) Банкны ажилтнуудад зориулсан цалин урамшууллын бодлогын баримт бичгийг боловсруулж, ТУЗ-өөр батлуулах;
 - (d) ГЗ болон удирдлагын багийнханд зориулсан урт хугацааны урамшууллын төлөвлөгөөг боловсруулж, ТУЗ-д зөвлөмж гаргах; Үндсэн цалин, урамшууллын хөтөлбөр болон ГЗ-д зориулсан урт хугацааны урамшуулалын төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, урт хугацааны урамшууллын хөтөлбөр болон бусад тэтгэмжийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, ГЗ-ын ажлын гүйцэтгэлийг жил бүр үнэлж, тухайн үнэлгээнд үндэслэн урамшууллын хэмжээг тогтоож, ТУЗ-д зөвлөмж гаргах, ГЗ-тай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах;
 - (e) Банкны эрх бүхий албан тушаалтны мэдлэг, ур чадвар, ажлын туршлага нь тухайн ажлын байранд тавигдах тусгай шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлох иж бүрэн үнэлгээ хийх, тэдгээр хүмүүс банкны стратегийн зорилтод үр дүнтэй хувь нэмэр оруулахад шаардлагатай ур чадварыг эзэмшсэн эсэхийг баталгаажуулах;
 - (f) ТУЗ-ийн шийдвэрийн үнэн зөв, бодитой байдлыг хангах, банкны засаглалын бүтцэд ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих зорилгоор эрх бүхий албан тушаалтнуудын хооронд үүсч болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг судлах, түүнд үнэлэлт өгөх, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хараат бус байдлыг шалгах;
 - (g) Хараат бус гишүүдийг сургах, мэргэшүүлэх цогц хөтөлбөрүүдийг зохион байгуулж, хяналт тавих, хараат бус гишүүдийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, тэдний

үндэслэлтэй шийдвэр гаргах, ТУЗ-ийн хэлэлцүүлэгт үр дүнтэй хувь нэмэр оруулах чадварыг нэмэгдүүлэх;

- (h) Хороо нь бүхий л үйл ажиллагаагаа үнэнч шударгаар, ТУЗ-өөс олгосон бүрэн эрхийн хүрээнд явуулна.

1.4 Хорооны нийтлэг чиг үүрэг нь Банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулагдана.

Хоёрдугаар зүйл. Хорооны зохион байгуулалт, бүтэц

2.1 Бүрэлдэхүүн, шалгуур:

- 2.1.1. Хорооны гишүүн нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй өөр бусад арилжааны банкуудын ТУЗ-ийн гишүүнээр ажиллахыг хориглоно. Хорооний гишүүнд нэр дэвшигч нь ТУЗ-д өөрийн мэдээллээ урьдчилан танилцуулж, түүний давхар эрхлэх ажил, үүрэг нь Хорооны ажилд нөлөөлөхгүй гэж ТУЗ-өөс үзсэн тохиолдолд давхар ажиллаж болно.
- 2.1.2. Хорооны гишүүн нь өөр бусад арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллагын ТУЗ-ийн гишүүнээр ажиллахыг хориглоно. Хэрэв Хорооны гишүүн нь өөр бусад компанийн болон Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкуудын ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллах тохиолдолд Банкны ТУЗ-д нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 2.1.3. Хорооны гишүүн нь Банкны тухай хууль болон Компанийн тухай хуульд заасан ерөнхий шалгуурыг хангахаас гадна ТУЗ-д ажиллаж байсан туршлагатай, компанийн засаглалаар мэргэшсэн байна.
- 2.1.4. Хорооны гишүүдийн гуравны хоёр нь хараат бус гишүүдээс бүрдүүлэх бөгөөд хорооны гишүүдийг сонгон шалгаруулахад хүйсийн тэнцвэрт байдлыг хангахыг эрмэлзэнэ.

Гуравдугаар зүйл. Хорооны үүрэг, хариуцлага

3.1 Хороо нь өөрийн бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлэх үүднээс дараах асуудлаар шийдвэр гаргах, ТУЗ-д зөвлөмж хүргүүлнэ:

3.1.1. Компанийн засаглал, түүний нийцэл:

- (a) Монголбанк (Төвбанк)-наас баталсан Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн засаглалын кодексийн хэрэгжилтэд хяналт тавих;
- (b) Банкны гүйцэтгэх удирдлага болон хөндлөнгийн аудитуудтай албан болон албан бус уулзалт хийх замаар ТУЗ-ийг шаардлагатай мэдээллээр хангах үйл ажиллагаанд хяналт тавих;
- (c) Банкны дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжаа болон түүний тайлагналын талаарх ерөнхий журмыг боловсруулж, хэрэгжүүлэх;

- (d) ТУЗ-өөр батлуулах асуудлыг боловсруулах, ТУЗ-өөр батлуулах шаардлагатай шийдвэрүүдийг тодорхойлж, зохистой засаглалын бүтэц, хэрэгжилтийн ил тод байдалд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд санал хүсэлтийг хүлээж авах;
- (e) ТУЗ-өөс батлах Компанийн ёс зүйн кодексийг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;
- (f) Банкны Санхүүгийн жилийн тайланд тусгагдах Компанийн засаглалын тайланг боловсруулж батлуулах;
- (g) ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн толилуулга Компанийн зохистой засаглалын зарчимд нийцсэн, хууль тогтоомжийн дагуу байгаа эсэхэд хяналт тавих;
- (h) Сонирхлын зөрчлийн нөхцөл байдал үүссэн эсэхэд хяналт тавих, үүссэн тохиолдолд зохих журмын дагуу мэдэгдэж байгаа эсэхэд хяналт тавих.

3.1.2. ТУЗ, түүний Хороодын бүтэц, үйл ажиллагаа:

- (a) Шийдвэр гаргалтын үр дүнтэй байдлыг хангах зорилгоор ТУЗ, түүний хороодын гишүүдийн бүтэц, бүрэлдэхүүнд хяналт тавих;
- (b) Банкны нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг үндэслэн ТУЗ-ийн гишүүний ур чадвар, хувийн зан байдал, бизнесийн мэдлэг, олон талын туршлагыг тогтмол үнэлэх замаар ТУЗ-ийн гишүүнийг сонгох шалгуурыг боловсруулах, хөгжүүлэх;
- (c) ТУЗ-ийн гишүүн болон хараат бус гишүүний шаардлага хангасан нэр дэвшигчийг тодорхойлж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хуралд зөвлөмж болгох;
- (d) ТУЗ-ийн хараат бус гишүүн томилох ажиллагаа нь Монголбанк болон Монгол Улсын банкны салбарт мөрдөгдөж байгаа болон хувьцаат компанийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих;
- (e) ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүнийг ТУЗ-д зөвлөмж болгох;
- (f) ТУЗ-ийн хурлыг зохион байгуулах, зохион байгуулалтад хяналт тавих;
- (g) ТУЗ, түүний хороодын үйл ажиллагаа, ТУЗ болон хороодын дарга, ТУЗ-ийн гишүүн тус бүрийн гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээг тогтмол хийж, дүгнэх;
- (h) ТУЗ-ийн гишүүдийг шаардлагатай сургалт, мэдлэг олгох хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулах.

3.1.3. ГЗ-ыг сонгох, урамшуулал олгох, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх:

- (a) Байгууллагын зорилго, зорилтыг тодорхойлж батлах;
- (b) Батлагдсан зорилго, зорилтын дагуу ГЗ-ын гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх;
- (c) Үнэлгээнд үндэслэн ГЗ-д олгох урамшууллын хэмжээг зөвлөмж болгох;
- (d) ГЗ-ын жилийн/урт хугацааны урамшууллын төлөвлөгөөг боловсруулж, ТУЗ-өөр батлуулахаар зөвлөмж гаргах, түүнийг хэрэгжүүлэх;
- (e) ГЗ-ыг сонгох, гүйцэтгэлийг үнэлэх, шаардлагатай тохиолдолд тухайн албан тушаалд өөр нэр дэвшигчийг зөвлөмж болгох;
- (f) ГЗ-ын залгамж халааны бодлогод хяналт тавих.